

Д/д	Оролцогчийн тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Үйлчилгээний хураамж</p> <p>i. Үйлчилгээний төлбөр хэд вэ?</p> <p>ii. Тендерт оролцогчид энэхүү үйлчилгээний төлбөрийг хэрхэн төлөх вэ?</p>	<p>Тендерийн үнэ 50,000 төгрөг ба Төрийн худалдан авах цахим систем https://www.tender.gov.mn/mn/rules/list - д байршуулсан Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын дагуу төлнө.</p>
2	<p>Тендерийн арга</p> <p>i. Энэхүү багц нь Чанар ба Үнийн Хосолмол Шалгуур (QCBS) тендерт хамрагдах уу?</p> <p>ii. Хэрэглэгдэх QCBS харьцаа ямар байх вэ?</p> <p>iii. Тендерт оролцогч үнийн саналыг тусад нь дугтуйнд хийж илгээх үү?</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн (цаашид Хуулийн гэх) 11.4.1 дэх заалтад заасан “харьцуулах үнэ”-ийн арга байна.</p> <p>Чанар ба үнийн хосолмол арга хэрэглэхгүй тул харьцаа байхгүй байна.</p> <p>Тендерийн баримт бичгийн V бүлэг: ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ хэсгийн “Маягт 1.Тендер илгээх маягт” -ын дагуу үнийн саналыг ирүүлнэ.</p>
3	<p>21.4</p> <p>"Тохируулахгүй тогтмол байна".</p> <p>Тендерт оролцогч нь маршрутын сонгон шалгаруулалтын үр дүнд үндэслэн, эцсийн зорилтот байгууламжийг баталгаажуулсны дараа нэмэлт ажил/судалгаа хийх талаар хэлэлцээр хийх боломж, нөхцөлийг тодорхойлохыг хүсэж байна.</p>	<p>Тендер шалгаруулалтын зааварчилгааны 21.4, Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 5.2-т гэрээний үнэ Тохируулахгүй тогтмол байна гэж заасан.</p>
4	<p>Тендерийн хэл</p> <p>i. Тендерт оролцогч тал нь тендерийн баримт бичгийг 'баталгаат орчуулгын төв'-өөр бус, Монгол багийн гишүүнээр орчуулуулсан байж болох уу?"</p> <p>ii. Захиалагч талаас англи хэл дээрх зарим бичиг баримтуудыг (олон улсын гэрчилгээ гэх мэт) Монгол хэл рүү орчуулах шаардлагаас чөлөөлж болох уу?</p>	<p>Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 12.1 болон 12.4 дэх заалтад заасны дагуу Тендерийн баримт бичгийг Монгол хэлээр бэлтгэж ирүүлэх ба тендерийн сонирхогч этгээд нь Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p> <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ/</i></p>
5	<p>Тендерийн баталгаа</p> <p>i. Тендерийн баталгааг ихэвчлэн Зөвлөхийн тендерт бус,</p>	<p>1.Захиалагч Хуулийн 14 дүгээр зүйл: “14.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч дараах тохиолдолд тендерийн</p>

	<p>Гүйцэтгэгчийн тендерт ашигладаг. Иймд тендерт оролцогч тал эдгээр баталгааг энэхүү тендерт ашигласан эсэхээ баталгаажуулахыг Захиалагчаас хүсэж байна.</p> <p>ii. Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2005 оны 20.2 дугаар зүйлийн 28.13-т заасны дагуу, Монгол банкнаас гаргасан албан ёсны хүүг ашиглах нөхцөлтэйгөөр гадаадын банкнаас гаргасан баталгааг хүлээн зөвшөөрөх боломжтой гэж бид ойлгож байна.</p>	<p>баталгаа ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана:</p> <p>14.1.1.багцгүй тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол,” гэж заасны дагуу тендерийн баталгааг ирүүлэх тухай Тендерийн баримт бичигт тусгасан.</p> <p>2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нь 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн батлагдсан болно. Энэ хуулийн 14.5-д “Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан журмын дагуу тендерийн баталгааг хүргүүлнэ.” гэж заасны дагуу тендерийн баталгааг ирүүлнэ.</p>
6	<p>Урьдчилгаа төлбөрийн баталгаа</p> <p>Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний нийт төлбөрийг хамарсан учраас урьдчилгаа төлбөрт “давхар баталгаа” шаардлагатай болсон шалтгааныг тодруулна уу.</p>	<p>Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай нөхцөлийн 5.4-т урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан.</p>
7	<p>Урамшуулал болон тусгай урамшуулал</p> <p>Тендерт оролцогч нь дараах асуудлаар тусгай урамшуулал болон үйл ажиллагааны онцгой нөхцөлүүдийг санал болгож байна. Үүнд:</p> <p>i. Татвар, ялангуяа давхар татвар,</p> <p>ii. Гадаадын шинжээч(үүд)-ийн ажиллах нөхцөл, зөвшөөрөл, түүний дотор VISA олголт,</p> <p>iii. Орлогыг эх орон руу шилжүүлэх санхүүгийн гүйлгээ.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.13-т “Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр гэрээний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай татвар, даатгал, тээвэрлэлтийн болон бусад бүх зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ.” гэж заасны дагуу үнийн саналаа ирүүлнэ үү.</p> <p>Гадаадын шинжээч(үүд)-ийн ажиллах нөхцөл, зөвшөөрөл, түүний дотор VISA олголтыг тендерийн сонирхогч этгээд бүрэн хариуцна.</p> <p>Төлбөрийг гадаад мөнгөн тэмдэгтээр гадаад улсын дансанд шилжүүлэхгүй.</p>
8	<p>Шаардлагатай лиценз</p> <p>Гадаадын инженерийн фирмийн хувьд бид сонгон шалгарсан даруйдаа PE байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ аргыг Монгол Улсын хууль, тогтоомжид үндэслэн журам, цаг хугацааны хувьд ашиглахыг зөвшөөрч байна гэж ойлгож байна.</p> <p>Бизнесийн лиценз (PE)-ээс гадна сонгон шалгаруулалт/гэрээний дараа түргэн авах шаардлагатай инженерийн тусгай зөвшөөрөл байгаа юу? Шаардлагатай</p>	<p>Тендерийн баримт бичгийн Тендерийн өгөгдлийн хүснэгийн ТШЗ 19.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг шаардах ба тендер шалгаруулалтын зааварчилгааны 19.4-т заасныг баримтална.</p>

	<p>журам, хугацааг хамарсан мэдээллийг бидэнд өгнө үү.</p>	
<p>9</p>	<p>55,300,000,000 төгрөгийн (16 сая ам. доллартай тэнцэх) төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний дараах зүйлсийн дэлгэрэнгүй мэдээллийг өгөхийг хүсэж байна:</p> <p>i. Ажлын даалгавар, тухайлбал;</p> <ul style="list-style-type: none"> o [Төслийн гарчгаас] Техник Эдийн Засгийн Үндэслэл буюу Маршрутын сонголтод ямар масштаб ашиглах ёстой вэ? (жишээ нь, 1:2,000, 1:5,000)? Төслийн бүрэлдэхүүн хэсэг нь туннел болон гол автозам руу орох гарцаар хязгаарлагдах уу, эсвэл Туул голыг гатлах гүүрийг багтаах шаардлагатай юу? o [Төслийн гарчгаас] ТЭЗҮ буюу Зураг төслийн ажлуудад үндэслэсэн FIRR болон EIRR-ийг тооцоолдог. Үүнд, ТХХТ гэрээний нөхцөлийг тодорхойлох зорилготой бөгөөд төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдэх зорилгогүй. o [Төслийн гарчгаас] Зураг төсөл боловсруулах гэдэг нь 1:1000 масштабтай Үндсэн Зураг Төсөл бөгөөд үүнд барилгын ажлын төлөвлөгөө, EPC гүйцэтгэгчийн жишиг загвар орсон урьдчилсан өртгийн тооцоолол багтах уу? o [Тодорхойгүй] Тендерийн баримт бичиг орсон эсэхийг тодорхойлно уу? Хэрэв орсон бол, FIDIC Silver Book эсвэл өөр ямар нэгэн стандартад үндэслэсэн байх уу? Мөн ТХХТ-ийн гэрээг тусдаа худалдан авах уу, эсвэл барилгын ажлын нэгтгэсэн нэг гэрээнд (жишээ нь, BOT эсвэл BOOT) байх уу? <p>ii. Үйлчилгээний хугацаа</p>	<p>1.Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын IV бүлгийн Стандарт, норм, нормативын баримт бичиг хэсэгт заасан.</p> <p>2.2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн цахим системд оруулсан Ажлын даалгаврын нэмэлт өөрчлөлттэй танилцана уу.</p> <p>3.Барилгын тухай хуулийн 4.1.30 дахь заалтад заасны дагуу ирүүлнэ.</p> <p>4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тул FIDIC болон өөр олон улсын гэрээ ашиглахгүй.</p> <p>Сангийн сайдын 2023 оны А/260 дугаар тушаалаар баталсан “Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу энэхүү тендерийн баримт бичгийг боловсруулсан болно.</p> <p>5. Үйлчилгээ үзүүлэх хугацаа 6 сар байна.</p>

10	Тендерийн валют Тендерт оролцогч тал төлбөрийг ам.доллараар хийх санал гаргаж байна.	Тендерийн баримт бичгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 22.1-т заасны дагуу тендерийн валют нь төгрөг байна.
11	ГЕН 3. Гүйцэтгэгч 3-р заалтад инженерийн зөвлөхийн бус, иргэний барилгын гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага хамаарна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд энэ заалтыг хэрхэн хэрэглэхийг дахин авч үзнэ үү.	Үнэлгээний хороо нь батлагдсан хууль болон журамд өөрчлөлт оруулах эрх, үүрэг байхгүй. Сангийн сайдын 2023 оны А/260 дугаар тушаалаар баталсан “Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу энэхүү тендерийн баримт бичгийг боловсруулсан болно.
12	ГЕН 5.6 Нэхэмжлэх Хамтарсан компани зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээр томилсон тохиолдолд, нэг(1) нэхэмжлэлд тус тусдаа гүйлгээтэй байж, 'хамтран болон дангаараа' зарчмыг ашиглан, туслан гүйцэтгэгчийг оролцуулан хэрэглэж болох уу?	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу түншлэл болон туслан гүйцэтгэгчийн тухай асуудлыг шийдвэрлэнэ. Мөн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 17 дугаар хэсэгт заасныг баримтална.
13	Гэрээний тусгай нөхцөл 5.4 Урьдчилгаа төлбөр Тендерт оролцогч нь дараах саналыг дэвшүүлж байна: Гэрээ байгуулах үед гэрээний нийт дүнгийн 30%-ийн урьдчилгаа төлбөрийг анхдагч шууд зардлуудыг (оффис байгуулах, судалгаа хийх, аялал, банкны хураамж болон бусад холбогдох зардлууд) төлөх зорилгоор олгох.	Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай нөхцөлийн 5.4-т урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан.
14	Гэрээний тусгай нөхцөл 5.5 Урьдчилгаа төлбөрийн хугацаа Урьдчилгаа төлбөрийг эхний төлбөрөөс эхлэн үе шаттайгаар буцаан олгож, нийт төлбөрийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 90 хувьд хүрэх үед бүрэн олгосон байх.	Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай нөхцөлийн 5.4-т урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан.
15	Гэрээний тусгай нөхцөл 5. Төлбөрийн хугацаа Тендерт оролцогч дараах төлбөрийн хуваарийг санал болгож байна: <ul style="list-style-type: none"> Эхний төлбөр (30%): Эхлэлийн шатны тайланг ирүүлсний дараа хийгдэх Хоёр дахь төлбөр (30%): Маршрут сонголтын тайланг ирүүлсний дараа хийгдэх 	Тендерийн сонирхогч этгээд нь тендер ирүүлэхдээ гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тусгах саналаа ирүүлэх нь нээлттэй байна.

	<ul style="list-style-type: none"> • Гурав дахь төлбөр (30%): Эцсийн шатны тайланг ирүүлсний дараа хийгдэх • Эцсийн төлбөр (10%): Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулсны дараа хийгдэх. 	
16	<p>Төлбөрийг хүлээн авах банк</p> <p>Захиалагч төлбөрийг зөвлөхийн гадаад дахь оршин суугаа улсын банкны данс руу шилжүүлэх боломжтой гэж ойлгож байна. Үүнийг баталгаажуулж өгнө үү.</p>	Төлбөрийг гадаадын дансанд шилжүүлэх боломжгүй.
17	<p>Ажлын даалгавар</p> <p>Үйлчилгээний хугацаа</p> <p>Зөвлөх үйлчилгээний 6 сарын хугацаа нь Маршрут сонгох, Үндсэн зураг төсөл боловсруулахад хэтэрхий богино байна. Тиймээс тендерт оролцогч нь засгийн газрын зөвшөөрлүүд авахад шаардагдах хугацааг багтаасан хуваарийн талаар нарийвчилсан тодруулга авахыг хүсэж байна.</p>	<p>1. Ажлын даалгаврын 8 дугаар бүлэгт баримт бичгийг бүрэн батлах хугацаа гэж ойлгож болно. /Эцсийн тайлан хүлээж авах хугацаа/</p> <p>2. Төслийн ТЭЗҮ болон зураг төслийг тус тус боловсруулах тодорхой хугацаа заагаагүй, сонирхогч этгээд ажил гүйцэтгэх хуваарийг гарган ирүүлнэ.</p>
18	<p>Ажлын даалгавар</p> <p>Төслийн багц/төслийн эхлэл ба төгсгөлийн цэгүүд</p> <p>Төслийн эхлэл ба төгсгөлийн цэгүүд зөвхөн туннелийн гарцууд хүртэлхээр заасан байгаа бөгөөд Туул голыг гатлах гүүрийн зураг төслийг зөвлөх үйлчилгээний хүрээнд багтаах эсэхийг тодруулна уу?</p>	2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн цахим системд оруулсан Ажлын даалгаврын нэмэлт өөрчлөлттэй танилцана уу.
19	<p>Ажлын даалгавар</p> <p>Нэмэлт даалгавар, ажлын дараалал</p> <p>Дараах ажлуудын хэрэгцээ:</p> <p>i. ТЭЗҮ-ийн баримт бичигт зориулсан инженер геологийн судалгаа хийхээс өмнө маршрут сонголтын судалгааг хэд хэдэн хувилбарын дагуу гүйцэтгэж, хамгийн тохиромжтой хувилбарыг сонгох шаардлагатай.</p> <p>ii. Хяналт тавих зөвлөхийн тендерийн баримт бичиг</p>	Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтэд зааснаас өөр нэмэлт шалгуур, даалгавар байхгүй.
20	<p>Ажлын даалгавар</p> <p>Туслан зөвлөхийн (Sub-consultant) ажлын хүрээ</p> <p>Төслийн уялдаа холбоо, техникийн нөхцөл хараахан тогтоогдоогүй байгаа тул доорх судалгаануудын хамрах хүрээ</p>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг тендерийн үнийн 20 хувиас дээш байна” гэж, 6.4-т “Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны

	<p>болон тогтмол түрээсийн хэмжээг зааж өгнө үү:</p> <ul style="list-style-type: none"> i. Геодезийн судалгаа ii. Геологийн судалгаа iii. Гидрологийн судалгаа iv. Тээврийн хөдөлгөөний судалгаа v. БОННУ, үүнд шаардлагатай зөвшөөрлийг авах. 	<p>этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно” гэж тус тус заасныг баримтална.</p>
21	<p>Зураг төслийн зорилт</p> <p>Туннел болон холбогдох автозамуудын хамт, зураг төслийн бусад байгууламжууд (жишээ нь, гүүр) болон тэдгээрийн тодорхойлолтыг (жишээ нь, урт, ROW) зэргийг тодорхойлно уу.</p>	<p>Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын II бүлгийн ХАМРАХ ХҮРЭЭ хэсэгт зааснаар тодорхойлно.</p>
22	<p>Эхлэх өдөр</p> <p>Өвлийн улиралд газрын гүний болон гадаргын ус хөлддөг тул зураг төслийн ажлын явцад гадаргуун шинж чанарыг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Тиймээс эхлэх өдрийг тодорхой зааж өгнө үү.</p>	<p>Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 4.1 хэсэгт заасан хугацаанд гэрээг байгуулна.</p>
23	<p>Бусад судалгааны ажил</p> <p>Дараах судалгааг хийх шаардлагатай бол техникийн үзүүлэлтүүдийг мөн тодорхойлно уу.</p> <ul style="list-style-type: none"> i. Салхины судалгаа ii. Right of way (ROW) судалгаа iii. Ашиглалтын судалгаа iv. Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 	<p>Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын V бүлэгт заасны дагуу судалгааны ажлуудыг хийнэ.</p>
24	<p>Ажлын даалгаврын заалт 2</p> <p>Үйлчилгээний хамрах хүрээ</p> <p>Үйлчилгээний эхлэх (BP) ба төгсгөлийн (EP) цэгүүдийн координатуудыг ажлын даалгаварт тодорхойлсон. Эдгээр координатын дагуу BP/EP цэгүүдийг одоо байгаа болон төлөвлөсөн авто замуудтай холбох хэсгүүд нь үйлчилгээний хамрах хүрээнд ороогүй гэж ойлгож байна. Энэ нь зөв эсэхийг баталгаажуулж өгнө үү.</p>	<p>Ажлын даалгаварт өгөгдсөн координатын цэг нь төслийн туннелийн хэсгийн хамрах хүрээг тодорхойлсон бөгөөд төслийн байршлыг Техник эдийн засгийн үндэслэлээр нарийвчлан тогтооно. Тус төсөл нь авто зам, гүүрэн байгууламж, туннел хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр нь зөвлөх үйлчилгээний хамрах хүрээнд багтана.</p>
25	<p>Хэдийгээр авто замтай холбогдох хэсэг нь Зөвлөх үйлчилгээнд ороогүй ч туннелийн төлөвлөгөө боловсруулахад дараах мэдээлэл шаардлагатай. Үүнд:</p>	<p>Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын 2.1, 2.10, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5 хэсгийг тус тус баримтална.</p>

	<p>i) Авто замуудын холбогдох эхлэлийн цэг (BP) болон төгсгөлийн цэг (EP) хаана байх вэ? (Тодруулбал, BP нь одоо байгаа авто замууд, төлөвлөсөн тойрог авто замууд эсвэл Туулын хурдны автоавтозамтай холбогдох уу?)</p> <p>ii) Авто замуудын холбогдох хэсгийн төлөвлөсөн бүтэц: жишээ нь, газрын түвшнээс дээш өргөгдсөн байдал зэрэг</p> <p>iii) Уулзварын төлөвлөлт: Ялангуяа, Туулын хурдны авто зам эсвэл хотын одоо байгаа автоавтозам дээрх уулзварын хэлбэр (IC хэлбэр)</p> <p>iv) Авто замын холбох хэсгүүдийн чиглэл</p> <p>Энэхүү мэдээлэл нь туннелийн төлөвлөлт, зураг төсөлд нөлөөлөх тул эдгээр мэдээллийг одоо эсвэл Үйлчилгээг эхлүүлэх үед авах боломжтой</p>	
26	<p>1999 оны 04-р сарын 20-ны өдрийн иргэний болон эрүүгийн асуудлаар хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн харилцааны тухай ОХУ, Монгол улс хоорондын гэрээний 15-р зүйлийн 1 ба 2-т заасны дагуу хэлэлцэн тохирогч талуудын аль нэгнийх нь эрх бүхий байгууллагаас албан ёсны тамга тэмдгээр баталгаажуулж, эрх бүхий этгээд гарын үсэг зурсан баримт бичгийг албажуулахгүйгээр Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт хүлээн авна. Энэхүү заалт нь холбогдох эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан орчуулга, баримт бичгийн хуулбаруудад хамаарна. Хэлэлцэн тохирогч талуудын аль нэгнийх нь нутаг дэвсгэрт албан ёсны гэж хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт мөн хүлээн зөвшөөрнө.</p> <p>Хуулиар зөвшөөрсөн байдалтай болгох шаардлага тавигдах эсэх талаар мэдэгдэнэ үү.</p> <p>а) Хэрэв ийм баримт бичгүүдийг ОХУ-ын эрх бүхий байгууллагаас гаргасан бөгөөд орчуулгыг Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэсэн бол;</p> <p>б) Хэрэв ийм баримт бичгүүдийг ОХУ-ын байгууллага болон «Институт Гидростроймост-Санкт-Петербург» Хувьцаат Компани бүрдүүлж гаргасан</p>	<p>Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 12.1 болон 12.4 дэх заалтад заасны дагуу Тендерийн баримт бичгийг Монгол хэлээр бэлтгэж ирүүлэх ба тендерийн сонирхогч этгээд нь Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>

	<p>бөгөөд орчуулга нь Монгол Улсын иргэн, эсвэл Монгол Улсад бүртгэлтэй байгууллагын хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гүйцэтгэсэн бол;</p> <p>в) Хэрэв энэ тодруулгын а, б -д заасан баримт бичгүүд Монгол улсын эрх бүхий байгууллага, орчуулагчийн гарын үсгээр баталгаажуулсан бол;</p>	
27	<p>Төслийн хүрээнд гүүр нэмэгдсэнтэй холбоотойгоор орчуулга амжихгүй, хугацаанд нь хүлээлгэн өгөхөд хүндрэлтэй, мөн төслийн чухал хэсэг болох гүүрийн саналыг сайжруулахын тулд хүлээлгэн өгөх хугацааг 12-р сарын 25 хүртэл сунгаж өгнө үү.</p>	<p>Тендерийн хүлээн авах эцсийн хугацааг дахин сунгах боломжгүй.</p>
28	<p>Ямар төрлийн Тусгай зөвшөөрөл хэзээний дотор хэрэгтэй болохыг Тодруулж өгнө үү.</p> <p>Мөн, Гадаадын компани тусгай зөвшөөрөл авахын тулд Монгол улсад төлөөллийн компанитай байх шаардлагатай үгүйг тодруулж өгнө үү.</p> <p>Бид Монгол компанитай туслан гүйцэтгэгчээр хамтран ажиллах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд хэрэв тэр компани нь тусгай зөвшөөрөлтэй тохиолдолд тухайн гадаад компани нь зөвшөөрөл авах шаардлагатай болохыг зааж өгнө үү.</p>	<p>Ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл байна.</p> <p>Түншлэл болон туслан гүйцэтгэгчийн тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйл, тендер шалгаруулалтын зааварчилгааны 17-д заасныг баримтална.</p> <p>ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.</p>